


МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШИНТНУУДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ НАЙМАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



THE MONGOLIAN BUDDHIST EIGHT-YEAR
CONSERVATION PLAN

IX Богд Жэвзүндамба хутагт



*БАЙГАЛЬ ОРЧНОО ХАЙРЛАН ХАМГААЛАХ
ТАЛААР МОНГОЛЫН АРД ТҮМЭНДЭЭ
ХАНДСАН 9 ЗҮЙЛ АЙЛДВАР*

1. Гурван эрдэнэ /бурхан, ном, хувраг/ дор чин сэтгэлийн залбирал үйлдэх

Шим ертөнц буюу 6 зүйлийн амьтад /тэнгэр, асури, хүмүүн, адгуус, бирд, там/, сав ертөнц буюу тэдний амьдарч байгаа газар дэлхий өнө удаан оршиж амар амгалан байх, даян дэлхийд гал, ус, цэрэг дайны болон бусад элдвийн гамшиг зовлон бүү учрах болтугай хэмээн сүсэглэн залбирах хэрэгтэй.

2. Монгол хүн болгон байгаль орчны талаар мэдлэгийг эзэмших

Орчин үеийн байгаль экологийн мэдлэгийг эзэмшихийн зэрэгцээ уламжлалт байгаль хамгаалах арга ухаан, ёс заншилдаа ямагт суралц.

3. Хүн бүр энгийн амьдрах

Хүмүүний шунал хязгааргүй, байгалийн нөөц баялаг хэмжээ хязгаартай. Иймд шуналын сэтгэл, илүү тансаг хэрэглээгээ хязгаарлаж, түүнд хяналт тавьж сур. Аль боломж бололцооныхоо хирээр энгийн амьдралыг эрхэмлэ.

4. Байгаль орчинд ээлтэй хөгжих

Аливаа хөгжлийг үгүйсгэж чадахгүй гэвч байгальд ээлтэй эерэг зөөлөн замаар хөгжлийг урагшлуулах хэрэгтэй. Иймд байгаль орчны тэнцвэртэй хөгжлийг эрхэмлэх нь зүйтэй юм.

5. Амьдралын зохистой орчинг бүрдүүлэх

Бохирдолгүй хөнөөлгүй байгаль орчин нь хувь хүний эрүүл мэнд, гэр бүлийн аз жаргал түүнчлэн улс үндэстний хөгжлийн үндэс суурь болно.

6. Түмэн бодисыг тэтгэгч чандмань эрдэнэ усаа хайрлах

Нуур цөөрөм, гол мөрөн, горхи, булаг шандыг хүндэтгэн хайрлан хамгаалж, бохирдол хөнөөлөөс сэргийлцгээе. Хүн бүр, айл бүр, албан байгууллага бүр усны хэрэгцээгээ хэмнэж, зөв ашиглацгаая.

7. Амьтдыг хайрлан хамгаалах

Ямар ч амьтны алтан амины үнэ цэнийг ухамсарлаж, тэднийг амь лугаа хагацуулах, гүжир муу нүгэл хилэнцийг үйлдэхийг тэвч. Ялангуяа ховор болон нэн ховор амьтны төрөл зүйлийг хайрлан хамгаалцгаая. Тэдгээр ан амьтны үс, арьсны хэрэглээг багасгая, эд эрхтэн амьтны гаралтай бүтээгдэхүүнээр хийсэн эд зүйлийг худалдаж авахгүй, хэрэглэхгүй байх.


8. Ой модоо хамгаалах, нөхөн сэргээх

Агаарын бохирдол, цөлжилтийн эсрэг хүн бүр мод тарьж байх ёстой. Үүнээс гадна одоо байгаа ой модоо хайрлан зохистой ашиглаж чадваас энэ нь хойч ирээдүйгээ бодсон нэгэн том алхам мөн.

9. Байгалийн далд баялаг болсон ашигт малтмал, эрдэнэсийг зохистой ашиглах

Газрын доорхи нөөц баялгийг энэ нас, ирээдүй хойчийн амьдрал зэргийг харгалзан алсын хараатай арвилан хэмнэж, ашиглах нь чухал юм. Уул уурхайн үйлдвэрлэл нь байгаль экологид эрсдэлтэй, хор хөнөөлтэй бөгөөд байнга араасаа муу үр дагаврыг дагуулж байдгийг ямагт анхаарахтун.

Энэ мэт Хутагт миний 9 зүйлийн сургамжийг, Монголын ард түмэн, сүсэгтэн олон та бүгд анхааран авч сэтгэл болон явдал мөрдөө хэрэгжүүлнэ гэдэгт гүнээ итгэж байна. Их Монгол орны маань ус нь цэнгэг, агаар нь цэвэр, газар шороо нь бүтэн, хүмүүн, амьтан нь айх аюулгүй, амгалан жаргалтай байгаасай хэмээн үнэн зүрхнээсээ хүсэж байгаагаа өчин айлтгая.



Эх болсон зургаан зүйлийн хамаг амьтан амгалан лугаа төгөлдөр байх болтугай.

МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШНЫ ТЭРГҮҮНҮҮД, НИЙТ СҮСЭГТЭН ОЛОНДОО ХАНДАН ИЛГЭЭХ ЗАХИДАЛ

Монгол Улсын Их
Хурлын гишүүн,
Засгийн газрын гишүүн,
Байгаль орчин,
аялал жуулчлалын сайд

Лүймэдийн ГАНСҮХ



Бурханы олон шавь, лам, хуврагуудаа!

Олон түмнийг гэгээрүүлэн сэнхрүүлж, эцэг болсон тэнгэр, эх болсон газар дэлхийгээ хайрлан хамгаалж, сав шим ертөнцийн хэвийн тэнцлийг хангаж, бодь сэтгэл, ариун үйлийг түгээн дэлгэрүүлэхдээ дараах хэдэн асуудлыг ямагт бодолдоо тээн, өргөн олон түмэнд хүргэн сэхээрүүлж байхыг та бүхэнд хандан уриалж байна.

Үүнд:

- Хүн гэдэг амьтан ухаан, нинжин сэтгэл, билгээрээ бусад амьтнаас ялгаатай ч муу хүсэл, шунал, хомхой сэтгэлийн гайгаар нүгэл хилэнц үйлддэг тухай, түүнээс салж ариун цагаан буяны мөрөөр орох "гарц"-ын тухай, байгаль хамгаалах уламжлалт монгол аргаа хойч үедээ хэрхэн өвлүүлэн үлдээх тухай, байгаль хамгаалах бодлогод шашны энэрэнгүй сургаал, зан үйлийг хэрхэн ашиглаж болох болон зон олныг энэ үйл ажиллагаанд татан оролцуулах тухай арга номлолуудыг орчин цагийн нөхцөл байдалд зохицуулж, хялбаршуулан тайлбарлаж, нийтэд сурталчлах зориулалтаар гарын авлага, цуврал илтгэл, ном, товхимлыг бэлтгэн хэвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх,
- Буян хийх, нүгэл үйлдэх, лус савдаг, лусын хорлол, догшин газар нутгийн тухай ойлголтыг аймаг, орон нутгийн онцлогуудтай уялдуулан тайлбарлах, ан амьтны цугларал / могойн чуулган/, үржлийн үед тэдэнд гай зовлон учруулбал өөрт ямар гай ланчиг үүрэх тухай бурхан, шашны номлолыг өргөн сурталчлах талаар орон нутгийн сүм хийдүүд, шашны зүтгэлтнүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх,
- Байгаль хамгаалах болоод бурхан, шашны сургаал, номлолын сэдвээр онол практикийн бага хурал хийх, мөн энэ чиглэлээр байгаль орчны мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудад илтгэл тавих, хичээл заах зэргээр хамтран ажиллах зэрэг болно,
- Уул овоо тахих болон олон нийтэд хандсан шашны зан үйл зохион байгуулахдаа байгаль орчныг доройтуулах хог хаягдал гаргах, гол ус бохирдуулах, мод бут хугалан гэмтээх зэргээс сэргийлэх арга хэмжээг бүрэн авах зэргээр хамтран ажиллацгаая.

*Эх болсон зургаан зүйл
Хамаг амьтны тусын тулд
Арван хар нүглийг тэвчин
Арван цагаан буяныг дэлгэрүүлж ажаамуу*

Мэндчилээ

Бурханы шашин анх дэлгэрсэн цагаасаа байгаль эх дэлхийгээ хамгаалах, эх болсон зургаан зүйл хамаг амьтныг хайрлах арга ухаан, тэдгээрийн шүтэлцэн орших хамаарлын хуулийг сургаж ирсэн.

Буддын гүн ухаан нь сав хийгээд шим ертөнцийн харилцааг нарийн тодорхой гаргаж, түүний дотор хүний сэтгэлийн ариуслаас гадаад сав ертөнцийн ариусал хэрхэн уялдаж байдгийг, байгаль орчны эдэрээтэй асуудлууд хүний дотоод сэтгэлийн бургас үүдэлтэйг тайлбарладаг билээ.

Иймээс эрт үеэс Бурханы шашны сүм хийд, лам нар байгаль эх дэлхийгээ хамгаалахад голлон үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд өнөөдөр дэлхий дахинаа Бурханы шашныг байгальд ээлтэй шашин гэдгийг нийт олноор хүлээн зөвшөөрч байна. Энэ нь орчин цагт Бурханы шашинтангуудын байгаль орчноо хамгаалах оролцоо хичнээн чухал байгааг, бидний зүгээс улам бүр хичээл зүтгэлийг шаардаж байна.

МБШТөв Гандантэгчэнлин хийд нь эх болсон байгаль дэлхийгээ хайрлан хамгаалахын төлөө Дэлхийн банк, Их Цутгал сан, Шашин ба Байгаль Хамгаалах Холбоо, Дэлхийн Байгаль Хамгаалах сан зэрэг олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж ирснийг цохон тэмдэглэхэд таатай байна. Эдгээр байгууллагуудын Монголын байгаль орчны төлөө явуулж буй төсөл санаачилгад талархаж байна.

Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Нийгүүлсэл ба Байгаль хамгаалал 2010” семинарт төр засгийн болон төрийн бус байгууллагууд, хот хөдөөгийн Бурханы шашны сүм хийдүүдийн ловон лам нар идэвхийлэн оролцож “Байгаль хамгаалах найман жилийн төлөвлөгөө”-г хэлэлцэн баталсан нь нэн сайшаалтай үйл явдал боллоо.

Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах үйлсэд хүн бүрийн итгэл, дэмжлэг, хүчин зүтгэл, оролцоо чухал гэдгийг бид бүгдийн цаашдын хамтын ажиллагаа харуулж чадна гэдэгт гүнээ итгэж байгаагаа илэрхийлэхэд баяртай байна.



Монголын Бурханы Шашинтны
Төв Гандантэгчэнлин хийдийн
тэргүүн хамба лам, гавж

Дэмбэрэлийн ЧОЙЖАМЦ

Монголын бурханы
шашинтнуудын байгаль
хамгаалах найман жилийн
төлөвлөгөөний ажлын
хэсгийн ахлагч,
Монголын Бурханы
Шашинтны Төв
Гандантэгчэнлин хийдийн
Да лам

Хүнхэрийн БЯМБАЖАВ



Өнөөдөр дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол маш хурдацтай явагдаж байгаа билээ. Үүний гол буруутан хүн төрөлхтөн өөрсдөө мөн.

Бурханы шашинд “Ертөнцийн буурал доройтол бүгд, ер түүний үндэс нь мунхаг агаад, алимад шүтэн барилдлагыг мэдснээр, аюул түүнийг буцаана” хэмээн айлдсан байдаг. Ийнхүү мунхаг гэдэг нь юмсын уг үрийн холбоо, хоорондын харилцан шүтэлцээг ул ухамсарласан сэтгэл оюуныг хэлнэ. Үүнээс үүдсэн аминч үзэл нь гэм алдаа, зовлон зүдгүүрийн бүгдийн үндэс болдог ажгуу.

Хүмүүсийн гадна талын материаллаг хөгжлөөс аз жаргалыг эрэлхийсэн эцэс төгсгөл, эмх замбараагүй хэрэглээ нь тэр хэмжээгээр эх дэлхийгээ цөлмөн сүйтгэн, түүний хариу нь сөрөг үр дагавар болж эргэн буусаар байна. Иймд гадаад сав ертөнц, дотоод шим ертөнцийн тэнцвэрт байдал хүн төрөлхтний ухамсарт үйл ажиллагаанаас л хамаарна. Өөрөөр хэлбэл бидний амьдарч буй байгаль орчин бол хүн төрөлхтний үйл буюу карма-аас шалтгаалдаг. Хүрээлэн байгаа орчны өөрчлөлт дотоод сэтгэлийн өөрчлөлтийн үр дүн хэмээн хэлж болно.

Өнөөдөр үндэсний уламжлалт сэтгэлгээ, боловсрол, хүмүүжил, ёс заншил алдагдсан. Түүнийг сэргээх чиг бодлого, бүрдэл нөхцөл бий болоогүй байна. Үүний хажуугаар ард иргэдийн экологийн мэдлэг муу, дээр нь төр засгийн дутуу дулмиг бодлого, уул уурхайн зохисгүй үйлдвэрлэл, ядуурал, ажилгүйдэл, эдийн засгийн доройтол зэрэг нь байгаль орчинтой зүй бусаар харьцахад нөлөөлж байгаа болно.

Иймд нийгмийн ёс зүйн хямралыг даван туулах, хувь хүний оюун санааг гэгээрүүлэх, нийгэм ба бусдын өмнө хүлээх ухамсар хариуцлагыг дээшлүүлэх үйл хэрэгт Монголын бурханы шашны хийд орон, лам хуврагууд хувь нэмрээ оруулах үүрэг хүлээх ёстой. Өнөөдөр ялангуяа хүн төрөлхтөний өмнө арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг ялгалгүй тулгамдсан зүйл бол байгаль орчны асуудал мөн. Дэлхийн шашнууд байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах үйл хэрэгт ихээхэн үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд энэ үүргээ ч цаашид гүйцэтгэх нь эргэлзээгүй ээ.

МБШашны лам хувраг, сүсэгтэн олон бүгд байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах ариун үйл хэрэгт нэгдэн хамтарч ажиллана гэдэгт итгэл дүүрэн байна.



МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШИНТНУУДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ НАЙМАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дэлхийн улс үндэстнүүдийн эрт дээр үеэс шүтэн биширч ирсэн шашин бүр ертөнцийг үзэх өөр өөрийн төсөөлөлтэй байдаг хэдий ч бүгд эх болсон байгаль дэлхийгээ хайрлан хамгаалахад ихээхэн үүрэг хариуцлага хүлээдэг билээ. Сүүлийн үед хурдацтай өсөн нэмэгдэж байгаа дэлхийн хүн ам болон түүнээс улбаалан бий болж байгаа байгалийн нөөцийн эрэлт хэрэгцээ нь оршин буй дэлхий ертөнц болоод амьд байгалийн орших, эс оршиход ихээхэн аюул занал учруулж байна.

Цаг уурын өөрчлөлт, байгалийн тэнцвэр, хүн байгалийн шүтэлцээ алдагдаж байгаа нь дэлхий дээр амьдарч буй бүхий л амьд биетийн өмнө тулгарч буй хамгийн том бэрхшээл болоод байна.

НҮБ болон Шашин ба Байгаль Хамгаалах Холбоо дэлхийн бүх томоохон шашнуудыг эх болсон дэлхийгээ аврах, хамгаалах ариун үйлсэд өөрсдийн хувь нэмрээ оруулахад нэгдэхийг уриалсан билээ. Ийнхүү дэлхийн 7 тивийн 30 гаруй шашны урсгал бүр “Байгаль хамгаалах найман жилийн төлөвлөгөөг” боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

2009 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр дэлхийн олон шашны тэргүүнүүд Английн Виндзор шилтгээнд хуран чуулсан юм. Шашин ба Байгаль Хамгаалах Холбоог үндэслэгч, Эдинбургийн хун тайж Филипп болон НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ки Мун дэлхийн шашнуудын найман жилийн төлөвлөгөөг хэрэгжиж эхлэж буйг дэлхийн нийтэд зарлан тунхагласан юм. Энэхүү үйл явдлыг НҮБ түүхэнд гарч буй хамгийн том иргэний нийгмийн хөдөлгөөн буюу дэлхийн байгаль хамгаалахад гарсан цөөхөн гол ажлуудын нэг байлаа хэмээн дүгнэсэн юм.

Бахай, Дао, Хинд, Еврей, Лал, Шинто, Синк зэрэг шашнууд тус тусдаа өөрсдийн төлөвлөгөөг боловсруулсан бол Христийн шашны 19 сүм хийд тус бүр төлөвлөгөөгөө боловсруулж гаргаад байна. Харин БНХАУ Шанхайгийн Бурханы шашинтнуудаар дамжуулан Байгаль хамгаалах найман жилийн төлөвлөгөөгөө боловсруулсан анхны Бурханы шашинт орон байсан бол Камбож, Монгол улс өөрсдийн төлөвлөгөөг боловсруулах зорилго тавьсан билээ.

Ийнхүү Монголын Бурханы шашины бүх сүм хийдүүдийн төлөөлөгчид хуран чуулсан “Нигүүлсэл ба Байгаль хамгаалал 2010” хурлаар Монголын Бурханы шашинтнуудын Байгаль хамгаалах найман жилийн төлөвлөгөөг боловсруулсан ба 2011 оноос эхлэн хэрэгжиж байна. Бидний санаачлагыг дэмжин хамтран ажиллах байгууллагууддаа талархал илэрхийлье.

**Эх болсон зургаан зүйл хамаг амьтаны тусын
тулд нэгдэцгээе!
Үм сайн амгалан болтугай!**

МОНГОЛЫН БУРХАНЫ
ШАШИНТНУУДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ
НАЙМАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

АГУУЛГА

УЛАМЖЛАЛ ЗАН ҮЙЛЭЭР:

- Уул, овоо, газар усны тахилга, дүлцэнгийн элс, лусын бумба өргөх зэрэг зан үйлийн үеэр лам хуврагууд байгаль хамгаалах талаарх уламжлалт мэдлэг ухааныг /уул овооны тахилгын ёс журам, бэлгэдэл цээр, сав шимийн ертөнцийн шүтэн барилдлага, сайн муу үйлийн үр, лус савдаг ба түүнийг баясгасны тус эрдэм, түүнийг хилэгнүүлсний хор уршиг, энэрэл нигүүлслийн сэтгэл гэх мэт/ олон нийтэд тайлбарлан таниулах;
- Лам хуврагууд нь сүсэгтэн олны ноён нуруу, зурхайд гарсан онгон байгаль, газар ус, уул модтой зүй бусаар харьцсанаас үүдсэн лусын хорлолын шалтгааныг тайлбарлаж, тухайн сэвтээсэн газар ус, уул модыг сэргээж лус аргадах, тахиx, хорлолыг буцаах зан үйлийн аргыг сайтар тайлбарлах (тухайлбал, мод тариулах, хог шороо цэвэрлүүлэх, амьтны амь авруулах зэрэг);
- Бурханы шашны энэрэнгүй ёсны зан үйл болсон ан амьтны амийг аврах, мал адгуусыг сэтэрлэх /амийг өршөөх/ уламжлалын ач холбогдолыг олон нийтэд таниулах;
- Бурхан тахил, тахилгат уул овоонд өргөл өргөхдөө байгальд хор нөлөөтэй (байгальд устдаггүй, олон зуун жилээр хадгалагддаг шил болон гялгар уут, хуванцар сав баглаа боодолтой) эд зүйлийн оронд мод, ургамлын үр, мал амьтны идэш тэжээл болохуйц хүнсний зүйлсийг дээжлэн өргөх тухай сүсэгтэн олонд таниулах, үлгэрлэх;
- Ховор болон нэн ховор ан амьтны ангийн бүтээгдэхүүн, ургамлыг өвчин эмгэг анагаах зорилгоор шууд ашиглах бус харин батлагдсан жор, тан хэрэглэхийн ач холбогдлыг олон нийтэд ойлгуулан таниулах;
- Ховор болон нэн ховор амьтан ургамлыг зүй бусаар агнах, түүх хийгээд ангийн гаралтай түүхий эд худалдан борлуулах, энэ үйл ажиллагаанд шууд болон шууд

бусаар оролцох, зугаа цэнгэл хөөн аливаа амьтны амийг таслахын үр дагавар, нүгэл хилэнцийг тайлбарлан таниулах;

- Хадаг өргөх уламжлалт ёс дэгийг сэргээх, хадагны зүй зохисгүй хэрэглээ, байгаль орчинд учруулж буй сөрөг үр дагаврыг сүсэгтэн олонд ойлгуулан таниулах, хадагны үнэ хүндийг дээшлүүлэх зорилготой “Хадаг Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх;
- Төрийн болон орон нутгийн уул овоо, газар усны тахилгыг нэгдсэн ёс журам, зан үйлийг тогтоон түүний дагуу үйлдэж занших;
- Уул овооны тахилгын судруудыг сурвалжлах, утга санааг орчин цагийн хэлэнд буулгаж, нутгийн иргэдэд сурталчлах;
- Уул, овоо, газар нутгийн нэрний түүх домог, утга санааг сурвалжлан нутгийн иргэд, ялангуяа хүүхэд залуучуудад таниулах;
- Сүм хийд барихад ашиглагдаж байсан байгальд ээлтэй уламжлалт аргуудыг судлах, сүм хийд шинээр барих, сэргээн засварлахад ашиглах, зөвлөх, ач холбогдлыг нийтэд сурталчилах;
- Шашны зан үйлийн баяр ёслол, тахилгуудад оролцож буй техник хэрэгслийн зогсоолыг тухайн газраас 500 метрээс доошгүй хол газар байрлуулж занших;
- Аливаа тахилга, шашны зан үйлийн баяр ёслол, нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахдаа хогийн цэг байгуулах, устгах арга хэмжээ авах, уг үйл ажиллагааг зохион байгуулах гэж буй байгууллагуудад энэ талаар сануулах, мэдэгдэх;
- Тахилгат газрын ойр орчимд шинээр хаягдсан хог хаягдлыг цэвэрлэх ажилд гар бие оролцон зохион байгуулах;
- Винай ёсыг эрхэмлэж, шаардлагагүй эд хөрөнгө хураалгүй, ханан мэдэлтэй байхын тухайд сүсэгтэн олонд сургах;
- Дүйчэн ба бусад өдрүүдэд мацаг барьсан, цагаан хоол идсэний ашиг тус, ач холбогдлыг ойлгуулж, уламжлалыг сэргээх;
- Унаган төрхөөрөө байгаа байгаль болон газар оронд шинээр зам гаргах, сүйтгэх, хог хаях зэрэг зохисгүй үйлийг гаргахгүй байхыг олонд таниулах;
- Сүм хийд бүр өөрсдийн сахиус шүтээн оршсон газар орныг сурвалжлах, шинээр бий болгохын зэрэгцээ тэдгээрт бэлгэдэл цээрийн ёс журмыг тогтоох;
- Байгалийн үзэсгэлэн цогцолсон болон түүх дурсгал, соёлын өв бүхий газар нутгуудад суварга шүтээн босгох зэргээр ариун дагшин газар болгон хамгаалалтанд авах.

СҮМ ХИЙДИЙН ХҮРЭЭНД:

- Сүм хийдэд усны сул алдагдлыг зогсоох, гамнах, хянах, зөв зохистой хэрэглэх ба хурын ус хураах ашиглах;
- Хийдийн гадаад, дотоод гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчний үүсвэрээр солих;
- Хийдүүд өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан байгаль хамгаалах байгууллага, хувь хүмүүс, мэргэжлийн хүмүүсийг урьж лам хуврагуудад яриа таниулга хийх;
- Шашны сургалттай сургууль дацангуудад сурч буй хүүхдүүдэд байгаль орчныг хамгаалах, экологийн боловсрол олгох тусгай хөтөлбөр боловсруулж сургалтын хөтөлбөрт оруулах;
- Сүм хийдүүд өөрсдийн хамгаалалтын бүс болон ашиглалтын бүсэд мод, цэцэг тарих зэргээр ногоон бүс байгуулах ажлыг өрнүүлэх;
- Сүм хийдүүд өөрсдийн хүнсний хэрэгцээгээ хангах зорилгоор хүнсий ногоо тариалах хүлэмж, ногооны талбай барьж байгуулах;
- Сүм хийд өөрсдийн хэрэгцээнд байгальд ээлтэй техник хэрэгсэл, цахилгаан хэрэгсэлийг худалдан авах;
- Байгальд устдаггүй гялгар уут, хуванцар савны хэрэглээг сүм хийдийн хэмжээнд эхний 2 жилийн хугацаанд тал хувиар багасгаж даавуун уут ашиглах, улмаар 2015 он гэхэд гялгар уутны хэрэглээг хориглох;
- Дүйчэн өдрүүдэд сүсэгтэн олонд цагаан хоолоор үйлчлэх, учир шалтгааныг тайлбарлан таниулах, үүнээс орсон орлогыг байгаль орчныг хамгаалах үйлсэд зориулах;
- Шинээр лам, хандмаа болж буй хүн бүр хамаг амьтаны тусын тулд бие сэтгэлээ зориулахын илэрхийлэл болгож залуу зулзган мод тарих, арчлан ургуулах ажлыг хэвшүүлэх;
- Жил бүрийг аль нэг ховор болон ховордсон ан амьтан, ургамал, байгалийн нөөцийг хамгаалах жил болгон зарлаж, холбогдох мэдээ мэдээллийг сүсэгтэн олон болон лам хуврагуудаа өгөх;

БОЛОВСРОЛООР:

- Олон нийтэд зориулж байгаль хамгаалах уламжлалт арга ухааны талаар мэдлэг өгөх;
- Ерөнхий боловсролын сургуулиуд болон их дээд сургуулиудад Бурханы шашны энэрэнгүй ёсны сургааль болоод уламжлалт байгаль хамгааллын сэдвээр илтгэл тавих, хичээл заах;
- Сүм хийдийн сургалтанд хамрагддаг сүсэгтэн олонд байгаль хамгаалах уламжлалт арга ухааны талаар тусгайлан цаг гарган яриа таниулга хийх;
- Ерөнхий боловсролын сургуулийн байгаль орчныг хичээлийн хөтөлбөрт байгаль хамгаалах уламжлалт ёс, зан үйл, мэдлэг ухааны талаар тусгахад хамтран оролцох;

ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛЭЭР:

- Сүсэгтэн олныг хамарсан байгаль орчныг хамгаалах аливаа үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгуулагуудтай хамтран ажиллах;
- Уламжлалт байгаль хамгаалах асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох;
- Бурханы Шашинтнуудын Байгаль Хамгаалах Найман Жилийн Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

УС БА УУЛ УУРХАЙН АСУУДАЛ

Монголчууд эртнээс усыг чандмань эрдэнэ, амьдралын эх булаг хэмээн үзэж, устай хүндэтгэлтэй хандаж ирсэн уламжлалтай ард түмэн. Улс орны хөгжил, байгаль орчны нөлөөнөөс ус бохирдох, гол ус ширгэх үзэгдэл жилээс жилд нэмэгдсээр байна. “Нигүүлсэл ба Байгаль хамгаалал 2010” ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Бурханы Шашинтнуудын Байгаль Хамгаалах Найман Жилийн Төлөвлөгөөнд гол ус, рашааныг хамгаалах, Монгол оронд түгээмэл учирч буй хариуцлагагүй уул уурхай, түүнтэй холбоотой нөхөн сэргээлтэнд тавих ард иргэдийн хяналтад өөрсдийн хувь нэмрээ оруулах зорилгоор “Ус ба Уул уурхайн асуудал” хэмээх бүлгийг тусгайлан оруулж байна.

- Сүм хийдийнхээ ойр орчимд байгаа гол ус, булаг шандны эхийг хамгаалалтанд авах, лам хуврага болон сүсэгтэн олны дэмжлэгтэйгээр гол горхи, булаг шандны эх дээр мод, бургас тарих, хашаа хатгах зэрэг ажлыг зохион байгуулах, шинээр суулгах мод, бут нь тухайн орон нутгийн уугуул ургамал байна.

- Тахилга шүтлэгтэй газар ус, гол мөрөн, уул овоонуудын ойр орчимд олгогдсон уул уурхайн зөвшөөрөл (лиценз)-ийн судалгаа гаргаж, цуцлуулах, дахин хянуулахад нөлөөлөх ажлыг зохион байгуулах;

- Гол ус, булаг шандны эрэг дээр хог хаягдлаа хаях, бохирдуулж (машин техник, хувцсаа угаах зэрэг) буй ард иргэдэд ухуулга сурталчилгаа хийх;

- Уламжлалт ёс заншил, газар усаа дээдлэх, уул уурхайн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зэрэг нутгийн иргэдийн санаа бодлыг төрийн байгууллагуудад уламжлах ажлыг зохион байгуулах;

- Нутаг, олон нийтээрээ тахин шүтдэг газар ус, уул овоо тэдгээрийн ойр орчмын газар нутаг, байгалийн үзэсгэлэнт газрууд болоод түүхийн өв соёлын дурсгалт газруудын хамгаалалтад хяналт тавих, энэ үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийн оролцоог дэмжих, шаардлагатай бол тухайн хууль, тэдгээртэй холбогдон гарсан журам, тогтоомжуудад өөрчлөлт оруулах санал тавих;

- Нутгийн олон, лам хуврагуудыг нөхөн сэргээлтийн жишиг газар нутгуудтай танилцуулах ажлыг зохион байгуулах, нутаг орондоо хэрхэн хэрэгжүүлэх талаар хэлэлцүүлэг зохион байгуулах;

- Уул уурхайн үйл ажиллагаа явуулах гэж буй болон явуулж буй газарт лус савдаг аргадах, шашны зан үйлээр газрыг авч өгөхгүй байх, лам хуврагуудыг шууд татан оролцуулахгүй байх;

- Нутаг орныхоо байгаль орчныг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хөдөлгөөн болон гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаагааг дэмжих.

ХАДАГ ХӨТӨЛБӨР

Монголчууд бид эрт дээр үеэс эдийн дээд нь хадаг хэмээн аав, ээж, өндөр настан, номын багш зэрэг хүндтэй хүндээ барихын сацуу хурдан морио мялаах, элч залах, зар хүргэх, эмч домчид бараалхахдаа хүндэтгэлийн илэрхийлэл болгон хэрэглэдэг байсан төдийгүй хадгийг мөнгөний нэгжний үүргээр үе дамжуулан ашиглаж байсан билээ. Харамсалтай нь өнөөдөр энэхүү уламжлал алдагдаж гудамж талбайн гэрлийн шон, гүүрний хашлага, бут сөөгний орой, булаг шандны эх, ургаа мод гээд хаа сайгүй хадгийг зүүж байгаа нь Бурханы шашинтан бидний сэтгэлийг хөндсөн асуудал болжээ. Иймд Монголын Бурханы шашинтнууд бид Байгаль Хамгаалах Найман Жилийн Төлөвлөгөөндөө Хадаг хөтөлбөрийг тусгайлан боловсрууллаа. Уг хөтөлбөрийн зорилго нь хадаг өргөх, тавих уламжлалт ёс дэгийг сэргээх, байгальд орчинд учруулж буй сөрөг үр дагаврыг сүсэгтэн олондоо ойлгуулан таниулах, улмаар хадагны үнэ хүндийг дээшлүүлэхэд оршино. Хөтөлбөр 2011-2015 он хүртэл хэрэгжинэ.

- Нутаг орон, сүм хийдийн ойр орчим болон хөдөө хээр босгосон суврага уул овоондоо хадаг уях тусгай мод босгох;
- Сүм хийдийн доторх бурхан шүтээнээс бусад, гадна босгосон суварга шүтээн, сангийн бойпор, хашаа хэрэм зэрэг болон хадагны модноос бусад зүйлд хадаг өргүүлэхгүй байх талаар сүсэгтэн олонд таниулах;
- Тахилгат газруудыг сэргээх ажлын хүрээнд хадагны модны хуучирч муудсан хадгийг авах, галд өргөх ажлыг зохион байгуулах;
- Зохистой бус газруудад /элдэв гүүр, замын уулзвар, ургаа мод, гэрлийн шон гэх мэт/ хадаг уяулахгүй байх, уясан хадагнуудыг цэвэрлэх ажлыг манлайлан зохион байгуулах;
- Торгон утас болон мяндсан утсаар нэхсэн хадгийг өргөн хэрэглэх, экспортлож байгаа, үйлдвэрлэж буй байгууллагуудыг дэмжих;
- Сүсэгтэн олонд нийлэг эдээр хийсэн хадагны байгаль орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг таниулах;
- Хадагны зохистой хэрэглээ, хүндэтгэл, үнэ цэнэ, байгальд учруулж буй хор хөнөөлийн талаар нэвтрүүлэг, баримтат кино хийж, олны хүртээл болгох



МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШИНТНУУДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Монголын Бурхан Шашинтны Төв Гандантэгчэнлин хийд Байгаль Хамгаалах Найман Жилийн Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллээр хангах төв болж ажиллана. Энэ үүргийг МБШТГандантэгчэнлин хийдийн Байгаль орчны алба гүйцэтгэнэ;
- Хөдөө орон нутаг болоод төвийн бүх сүм хийдүүдийн ловон лам нар тус бүрийнхээ байгаль хамгаалах асуудлыг хариуцах ба хэрвээ шаардлагатай бол туслах мэргэжилтэн томилж болно;
- Орон нутгийн сүм хийд бүр МБШТГандантэгчэнлин хийдийн Байгаль орчны албанд улирал бүрийн ажлын төлөвлөгөө, тайлангаа улирал бүрийн эхний сарын 15-ны дотор ирүүлж байна;
- Сүм хийд бүр Байгаль Хамгаалах Найман Жилийн Төлөвлөгөөтэй уялдсан өөрийн жил бүрийн төлөвлөгөө гаргаж, сүм хийдээрээ мөрдөн хэрэгжүүлнэ;
- МБШТГандантэгчэнлин хийд өөрийн нөөц бололцоогоо ашиглан байгаль хамгаалах салбарт манлайлан оролцоно.


“Байгаль Хамгаалах Сан” байгуулах тухай:

- Сүм хийд бүр өөрийн байгаль хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор сүм хийдийн сар бүрийн нийт орлогын 5% тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг “Байгаль Хамгаалах Сан”-даа байршуулах;
- Сүм хийд бүр өөрийн “Байгаль хамгаалах сан”-гийн дүрэм, зарцуулалтын журмыг тогтооно.





His Eminence IX Khalkha Jetsundampa



**NINE-POINTED HEART ADVICE ON
ENVIRONMENTAL PROTECTION**

1. Pray to the Three Supreme Jewels (Buddha, Dharma, Sangha) from the bottom of your heart.

Pray with a strong faith for both the living world, with its six types of beings (gods, demi-gods, humans, animals, hungry spirits and beings in hell) and the material world or the earth where they live. And pray for them to be in peace, without danger of fire, water and war or any other disasters.

2. Acquire knowledge of the environment and ecology.

Besides acquiring modern ecological knowledge, all Mongolians should learn traditional wisdom and customs for protecting the environment.

3. Live simply.

Human desire is endless, but natural resources are scarce. Therefore limit your desire for luxurious or opulent consumption and try to control it. As much as possible, prefer a simple way of living.

4. Development has to be environmentally friendly.

Development can be a good thing, but it is necessary for it to be environmentally friendly. It is important for Mongolians to assure that development is balanced and well planned.

5. Facilitate a healthy environment for healthy living.

An unpolluted, non-hazardous environment is the basis for the health of every individual, the happiness of the family and the development of the nation.

6. Save water, which is precious as a wish-fulfilling gem and which nurtures life and the elements.

We should protect our lakes, rivers, streams, brooks and springs from pollution. And every person, every family and every organization should save water and be ecologically aware when using water.

7. Love and protect animals.

Be aware of the preciousness of any living being's life and avoid committing unwholesome actions by taking a life. Particularly, have special concern for scarce animal species. Reduce consumption of furs and skins, and do not consume or buy the organs and products of endangered animals.


8. Conserve and restore the forest.

Everyone should plant trees and care for them after planting to stop air pollution and desertification. If we can protect them and be prudent in their usage, forests can be a great gift for our future generation.

9. Use underground resources and minerals properly.

Wisely use but also protect underground resources, conserving them with open minds. Always remember that mining can be harmful to ecological systems and bad consequences can result.

I deeply believe that Mongolians and disciples will take into consideration my advice on these nine points as Jetsundampa, and apply them in their thoughts and actions. I sincerely wish that Great Mongolia's waters stay pristine, its air fresh, its territory whole, and its people happy and free from danger.



**May all sentient beings abide
in happiness and peace.**

A MESSAGE TO MONGOLIAN BUDDHIST LEADERS AND DEVOTEES

GANSUKH LUIMED

Mongolian Parliament
Member, Cabinet Minister
The Minister of Nature,
Environment and Tourism



Dearest Buddhist Devotees and Venerable Monks,

When you educate and enlighten the public with religious teachings, worship the sky as a father and nature as a mother, preserve the equilibrium of the environment, spread compassionate thinking, and kindly keep the following points in mind:

- We humans are fortunate to have intelligent minds, wise understanding and generous hearts. Nonetheless, we are also prone to bad thoughts, greed and lust, and we sin through our own doings. Thus, modify religious teachings to fit modern times, interpreting them in plain language; publish booklets and present lectures about how we can rid ourselves from sin; transfer knowledge of traditional conservation practices to the next generation; apply compassionate Buddhist teachings and customs to protect nature; and reach out to the public about conserving nature through righteous and compassionate teachings.
- Guide your local monasteries and religious leaders on ways to explain to the public the aspects of merit, sin, spiritual land possessors (nagas), and conception of sacred sites in accordance with the region's distinctive characteristics. Moreover, through religious teachings, make people aware that it is sinful to harm wildlife during the breeding season or natural (naga) gatherings.
- Let us work hand-in-hand by organizing seminars and workshops, as well as offering lectures and teachings about conserving nature, at universities and institutes that educate future environmental specialists.
- Let us not spoil the beauty of Mother Nature by polluting the rivers, hurting the trees and destroying the natural habitat during Ovoo worship and other religious ceremonies.

Greetings

Ever since Buddhism spread throughout the world, it has been teaching love and protection of nature, respect of all sentient beings, and the interconnect-
edness of all elements of nature.

Buddhist philosophy teaches about the organic and the non-organic world, the relationship between the two, and especially how the outer world impurities connect with the impurities of the human mind. It says that complicated environmental issues arise from corruption of the human mind.

Thus, Buddhist monasteries, temples and monks have played a significant role in the protection of nature. Buddhism is recognized as the most nature-friendly religion in the world. It is important to involve Buddhist philosophies in the protection of nature while at the same time asking for much more effort and commitment from us.

It is a great pleasure to emphasize that Gandantegchenlin Monastery has been collaborating closely with the World Bank, The Tributary Fund, The Alliance of Religions and Conservation, and World Wildlife Fund to conserve Mother Nature. We fully appreciate the work of these organizations to protect nature in Mongolia.

It is praiseworthy that the representatives of the "Buddhist Compassion and Conservation 2010" conference, along with representatives from governmental and non-governmental organizations, have approved this "Mongolian Buddhist Eight-Year Conservation Plan".

I am pleased to express my deep commitment to continue our collaboration and to support our collective beliefs, efforts and involvement in the protection of nature.



Venerable
CHOIJAMTS DEMBEREL,

The Abbot of Gandantegchenlin
Monastery, The Center of
Mongolian Buddhists

Greetings

Venerable
BAYAMBAJAV KHUNKHUR

The Da lama of
Gandantegchenlin Monastery,
The Head of the Mongolian
Eight-Year Plan Committee



Today global climate change and environmental degradation are proceeding with great speed. We humans are the offenders.

Buddhism says that the way we think is at the source of environmental degradation; therefore, we must seek to think more purely about the interconnectedness of all beings. Endless and disordered personal consumption in an effort to seek happiness actually destroys nature. Thus, the proper balance between the outer organic world and the inner non-organic world is related to human consciousness. In other words, the nature we live in depends on the actions of mankind or its karma. All the changes of our environment are outcomes of the changes in our mind.

Unfortunately, nowadays, we are losing our traditional education, customs, and Mongolian way of thinking. There are no adequate policies or conditions for reintroducing these values. Moreover, circumstances such as insufficient knowledge of environmental impacts, the lack of state enforcement, irresponsible mining, poverty, unemployment and economical weakness ultimately cause harm to nature.

Therefore, Mongolian Buddhist monks and monasteries should contribute to overcome social and ethical crises by enhancing the personal spirit as well as encouraging personal responsibility to society and others. Today, habitat and species conservation are becoming crucial issues for mankind without distinction of race, nationality and religion. Thus every religion in the world must play a significant role in the protection of nature.

I am confident that Mongolian Buddhist monks, nuns and devotees will collaborate closely to protect Mother Nature.



THE MONGOLIAN BUDDHISTS EIGHT-YEAR CONSERVATION PLAN

INTRODUCTION

Even though all religions have their own worldviews, they are all deeply linked to conservation of nature, and have a great responsibility in this field. Rapidly growing population and increasing demand for natural resources have endangered our blue planet. With world climate change and poor understanding of the interrelation between mankind and nature, all living beings on this earth are facing the same challenges.

The United Nations Development Programme (UNDP) and The Alliance of Religions and Conservation (ARC) have challenged every major religion to make a contribution to preserve the planet through creating long-term action plans. In response, so far over 30 major religious traditions around the world have developed their own plans for the conservation of nature.

On November 4, 2009, eminent global religious leaders gathered at Windsor Castle. There, His Royal Highness Prince Philip and the Secretary-General of the United Nations, Ban Ki-moon, jointly announced the implementation of a first series of long-term plans. The work of the faiths on the environment was highlighted by UNDP as the biggest societal movement on climate change.

Representatives from Baha'ism, Daoism, 17 Christian traditions, Buddhism, Hinduism, Judaism, Islam, Shintoism, and Sikhism developed the plans. While China was the first Buddhist country to initiate an Eight-Year Plan, through the Buddhists of Shanghai, Mongolia has now developed its own, and monks in Cambodia are also looking at their long-term program.

In the second "Compassion and Conservation" conference in 2010 with over 50 representatives from monasteries and temples from all over the country, Mongolian Buddhists elaborated the "The Mongolian Buddhist Eight-Year Conservation Plan" which started in January 2011. Our great appreciation to all those collaborating on and supporting this work. Let us come together for the benefit of sentient beings!

May all be happy!

GENERAL CONTENTS OF THE MONGOLIAN BUDDHIST EIGHT-YEAR CONSERVATION PLAN

THROUGH TRADITIONS

- Buddhist monks and nuns will acknowledge the importance of conservation from a Buddhist viewpoint. We will respect traditional regulations on mountain-, Ovoo-, and water-worshipping ceremonies; the relationships between the organic and non-organic; the law of karma; the role of nagas as guardians of sacred land; the benefits of praising the nagas and the harms of arousing their anger; and compassion. We also will:
- Give lay devotees good explanations of the causes of harm from the nagas. If an individual who damages or pollutes sacred lands, waters, mountains or trees comes to monks for spiritual consultation, we will advise him or her to restore the damaged lands. We will recommend and observe traditional practical solutions to pollution such as planting trees, collecting litter and garbage, and saving animal lives.
- Promote the benefits of compassionate rituals of Buddhism such as saving animal lives. In a contemporary context this does not just mean passively not killing, but requires active protection of animals, especially rare and endangered species of which Mongolia has several.
- Provide advice and make personal examples by making healthy choices for offerings to shrines and Ovoos such as seeds of trees and plants and food that is edible by wild animals. We will not offer items in plastic bags and glass containers.
- Support use of approved traditional medication to treat illnesses instead of using parts of endangered wild animals and plants.
- Help stop wildlife trade by explaining the consequences of hunting and collecting endangered species, of direct and indirect participa-

tion in species and animal part trading, and of killing of animals for recreation.

- Preserve the khadag offering tradition, and will speak on the negative influence on nature when khadags are not used properly. We will implement a "Khadag Program" to provide good public understanding of the value of khadags.
- Research and rediscover sutras relevant to the worship of mountains, Ovoos and water throughout Mongolia, and translate them into modern Mongolian for local distribution.
- Study the names and legends of sacred mountains, Ovoos and lands and present that research to locals, especially young generations, in an understandable way.
- Research ancient eco-friendly materials used to build monasteries and temples, and reintroduce these techniques for new monasteries and temples, and for restoration of existing ones. Where this is done, we will provide information to the public about its significance.
- Limit vehicle parking to at least 500 meters from ceremonial areas.
- Use trash receptacles during every ceremony, and notify those organizing such ceremonies about the trash care issue.
- Organize groups to clean ceremonial areas during and after ceremonies.
- Practice the Vinaya vow and live as simply as possible, without unnecessary possessions.
- Reintroduce the tradition of vegetarianism and its benefits during religious observation days. Traditionally the 8th, 15th and last day in the Mongolian month are special days when meat is not eaten. This is an old monastic tradition that can be promoted to the wider public.
- Prevent the public from damaging or polluting natural landscapes when creating new roads, digging, and displacing soil unmindfully.
- Conduct research by every monastery on the sacred land where its deity is believed to dwell. If a monastery does not have such land, it will find a new place and create regulations on relevant symbols and prohibitions.
- Build stupas at or near monasteries in beautiful landscapes and historical areas, protecting them according to Buddhist conservation practices.

RULES WITHIN MONASTERIES:

We will:

- Prevent waste of water by developing efficient water transportation systems and using rain collection barrels.
- Introduce solar power into monastery energy plans.
- Invite ecology experts to provide teachings to monks, and we will develop and introduce a special ecology curriculum into monastic schools.
- Create “green” open gardens, and no-development zones at monasteries.
- Build greenhouses and gardens to provide vegetables for monastic needs.
- Purchase nature-friendly vehicles and equipment for monastic needs.
- Reduce the use of plastic bags in the monastery by half within two years, and through gradual introduction of reusable cloth bags, we will discourage or prohibit use of plastic bags in monasteries by 2015.
- Serve devotees vegetarian meals during religious observance days, and explain why. We will dedicate profits to conservation projects from selling vegetarian meals.
- Plant a tree sapling when a new monk or nun joins the monastery, as part of their commitment to serve the world. Their commitment will extend to taking care of the sapling.
- Create a special conservation theme for each year devoted to protection of endangered species and natural resources. Related information will be disseminated to monks and the public during the year.

THROUGH EDUCATION:

We will:

- Provide the public with information on traditional conservation wisdom.
- Give lectures and presentations to schools and universities on the compassionate teachings of Buddhism and the traditional wisdom of conservation.
- Present frequent talks to lay devotees on Buddhist conservation wisdom.
- Contribute to the national environmental education curriculum.

THROUGH THE MEDIA:

We will:

- Collaborate with the media and press to raise public awareness on the conservation of nature.
- Organize and participate in open discussions with the media on traditional conservation methods.
- Publicize the Eight-Year Plan and its implementation through broad media channels.

SPECIAL INITIATIVE:

WATER AND MINING

For centuries Mongols have regarded water as the source of life, treating it with pure respect. With development and its impact on natural resources, water quality and quantity have been affected and rivers and lakes dry up every year. As a result of the “Compassion and Conservation 2010” conference, a new initiative on mining issues was added into the Eight-Year Plan priorities. Essentially, Buddhist leaders are now asking for better civil protection of water resources and related land resources. To play their role, Buddhist monks and nuns will:

- Protect water sources around monasteries and temples and, with assistance from devotees and monks, plant trees and set up fences to preserve them. The trees will be local ones, which will grow well in the local environment.
- Carry out research on mining licenses that are obtained for exploration in worshipped areas such as mountains, Ovoos, and water; have an influence with authorities on canceling and reconsideration of permits.
- Make government organizations aware of locals who are contributing to the maintenance of mountain-, Ovoo- and water-worshipping rituals; strengthen the civil supervision of mining projects near those areas.
- Supervise and protect commonly worshipped mountains, Ovoos, waters, beautiful landscapes and historically related areas, and support the civil involvement of locals. Be influential in terminating unfair regulations and laws if necessary.
- Organize study tours for monks and nuns to learn about restoration projects. Engage in discussion on how to implement this new knowledge.
- Not get involved directly or indirectly in naga-praising and land-taking ceremonies for mining purposes.
- Cooperate with NGOs, civil movements and international organizations for the protection of nature, and support activities of these organizations.



SPECIAL INITIATIVE: KHADAG PROGRAM (TRADITIONAL SCARF)

For centuries, Mongols have been using khadags as a deep expression of respect for their fathers, mothers, seniors, and dharmic teachers, as well as for blessing horses, inviting messengers, delivering important message and visiting medical doctors. Also khadags were once used for monetary exchange. Today this sacred tradition has been subverted and we find khadags everywhere tied to street light poles, bridges, and trees. This misuse of khadags has become a serious issue for Buddhists. Nylon khadags do not degrade, and can stunt the growth of trees and catch on birds' feet and hurt them.

Mongolian Buddhists add this Khadag Program to this Eight-Year Plan with the objectives of restoring the tradition of khadag offerings, creating public awareness of the need to protect nature and avoid poor practices, and reminding devotees of the value of khadags. This program will be implemented from 2011 to 2015 with the following goals:

- Create a special khadag pole near monasteries, worship areas, countryside stupas, Ovoos and mountains.
- Ask devotees not to tie khadags to stupas, incense burners, fences and other improper places. Encourage them to use only the main shrines inside monasteries or nearby khadag poles. Help devotees become familiar with this regulation.
- Encourage devotees not to tie khadags to bridges, road junctions, live trees and street lamp poles. Also, organize a group for removing khadags tied to such places.
- Encourage use of silk or other eco-khadags, and support factories making them.
- Create an awareness of impacts from using nylon or non-biodegradable khadags.
- Make a documentary film on khadag traditions, value and proper usage, as well as their negative impacts.

STRUCTURE FOR IMPLEMENTING THE MONGOLIAN BUDDHIST EIGHT-YEAR CONSERVATION PLAN

- Gandantegchenlin Monastery, the Center of Mongolian Buddhists, is the umbrella organization for supervising and providing information on the Eight-Year Plan. Its Office of Conservation will be responsible for these actions.
- Head lamas of every rural or urban monastery will be in charge of conservation at his monastery and an assistant can be appointed if necessary.
- Every rural monastery will submit a seasonal work plan and report to the Office of Conservation at Gandantegchenlin Monastery within the first 15 days of every three-month period.
- Every monastery/temple will develop its own yearly conservation program as part of the Eight-Year Plan. They will be encouraged to send this program to Gandantegchenlin Monastery.
- To create funding for special conservation projects for its Eight-Year Plan, each monastery will contribute five percent of its income to its own Conservation Fund.
- Each monastery will establish special rules and procedures for disbursing the Conservation Fund.





Нидерландын Вант Улсын Засгийн Газрын Итгэлийн Сангийн дэмжлэгээр Монгол улсын Байгаль орчин, Аялал жуулчлалын яам, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Байгаль Орчны Шинэчлэл – 2" төслийн хүрээнд АНУ-ын "Их цутгал" сан болон Шашин ба Байгаль хамгаалах холбоотой хамтран бүтээв.

Accomplished in partnership with The Tributary Fund and The Alliance of Religions and Conservation (ARC). The World Bank managed the Dutch Government's NEMO II funding.

Х.Бямбажав
Л.Чулуунчимэг
Д.Амарболд
Б.Мөнхбаатар
С.Даваапүрэв
Д.Ухаанзаяа

Ажлын хэсгийн ахлагч, МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Да лам
АНУ-ын "Их Цутгал" сангийн Монгол дахь хөтөлбөрийн зохицуулагч
МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Байгаль орчин хариуцсан ажилтан, Мамба дацан хийдийн ловон лам
МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Гадаад харилцааны албаны дарга
МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Олон нийттэй харилцах албаны дарга
Бурхан урлаач, "Цаглашгүй гэрэлт" шүтээн урлалын төвийн тэргүүн